

ЭДИЙН ЗАСАГ, ДААТГАЛЫН АЛБА:

1. Бүтэц, зохион байгуулалт:

- ✓ Тасгийн эрхлэгч-1
- ✓ Эрүүл мэндийн даатгалын их эмч-4
- ✓ Даатгалын оператор-2
- ✓ Эдийн засагч-1
- ✓ Эрүүл мэндийн даатгал хариуцсан нягтлан бодогч-1
- ✓ Мэдээллийн технологийн инженер-1

хүний бүрэлдэхүүнтэй ажиллахаар нийт 10 хүний бүрэлдэхүүнтэй бүтэц, орон тоо батлагдсан бөгөөд 8 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.



2. Үйл ажиллагааны чиглэл:

- ✓ Байгууллагын санхүү, эдийн засгийн удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх, орлого бүрдүүлэх, төсвийн төлөвлөлт болон зарцуулалтад шинжилгээ хийх, Эмнэлгийн тусламж үйлчилгээний өдөр тутмын үйл ажиллагааны эрүүл мэндийн даатгалын мэдээллийг өдөр тутам, сар, улирал, жилийн байдлаар тайлагнах, Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих тусламж үйлчилгээний нэхэмжлэлийг нэгтгэн зохион байгуулах, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай байгуулсан тусламж үйлчилгээ худалдан авах гэрээний биелэлтийг хангах, Эрүүл мэндийн тухай хууль, ЭМДҮЗ-ийн тогтоолын талаар эмнэлгийн эмч, мэргэжилтнүүдэд сурталчлах, сургалт зохион байгуулах, үйлчлүүлэгчийг мэдээллээр хангах, байгууллагын хэмжээнд бүтээгдэхүүний өртгийн судалгаа хийх,

зарим оношилгоо, эмчилгээний өртгийг тооцох үндсэн чиг үүргийн дагуу
үйл ажиллагааг өдөр тутамд зохион байгуулан ажилладаг.